6	10.2.3а. Техникийн нэгж угсрааны бүтцийг тодорхойлохдоо эд ангиудын кинематик схем дахь тэмдэглэгээг харьцуулах аргаар хүч хөдөлгөөний зарчмыг механикийн онолоор тайлбарлах 10.2.3б. Электроникийн тухай ерөнхий ойлголтыг тайлбарлахдаа хагас дамжуулагч, диод, эсэргүүцлийг танилцуулж хөгжил хэрэглээг илрүүлэн дүгнэлт хийх 10.2.3в. Цахилгаан үүсгүүрийн төрөл, хэлбэрийг харьцуулан жишиж, хэрэглээг тодорхойлон зөв сонгох 10.2.3д. Хийцийн материалын ангилал төрөл, шинж чанарыг жишээн дээр тайлбарлах 10.2.3е. Идэвхгүй электрон элементийн төрөл бүтэц, ажиллах зарчмыг харьцуулах аргаар үүргийг тодорхойлж, зөв сонгох 10.2.3г. Техникийн хөдөлгөөнт бүтээлийн дизайн шийдэл гаргахдаа зохиомжийн аргаар загварчлан зурж, шинэлэг загвар бүтээх 10.2.3ж. Техникийн хөдөлгөөнт бүтээл хийхдээ төслийн аргаар үйл ажиллагаагаа төлөвлөж, технологийн зөв дарааллаар боловсруулалт хийх 10.2.3з. Техникийн хөдөлгөөнт бүтээлийн ажиллагааг шалгахдаа электрон элемент ба механик эд ангиудын угсралтын схемийг ашиглан хөдөлгөөний тохиргоо хийх	Механик электроник	ДЗЗТ10.2.3.ҮД9. Сурагч техникийн эд ангиудын кинематик схемийг уншиж, хөдөлгөөний зарчмыг тайлбарлаж чаддаг болно. ДЗЗТ10.2.3.ҮД10. Сурагч цахилгаан үүсгүүрийн төрөл болон электроникийн энгийн элементүүд (хагас дамжуулагч, диод, эсэргүүцэл) хийцийн материалын хэрэгцээг тодорхойлж, бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгож чаддаг болно. ДЗЗТ10.2.3.ҮД11. Сурагч электроникийн энгийн элементүүд ашиглан техникийн хөдөлгөөнт бүтээл хийж, бүтээлийн ажиллагаа, хөдөлгөөнд тохиргоо хийж чаддаг болно.
7	10.2.4а. Үндэсний уламжлалт технологийн төрөл, ангилал, дизайн, хийц технологийн онцлогийг жишээгээр тайлбарлах 10.2.4б. Баримал, шуумал, сийлбэр, дархан, хатгамал, эсгий урлал, арьсан урлал хийх уламжлалт технологи, арга барилыг ашиглан хэрэглээний бүтээл урлах 10.2.4в. Үндэсний хэв маягийг хадгалсан, бизнесийн зориулалттай жижиг бүтээл (бэлэг дурсгалын зүйл)-ийн загвар зохион бүтээх	Уламжлалт технологи	ДЗЗТ10.2.4.ҮД12. Сурагч уламжлалт гар урлалын технологиор (баримал, шуумал, сийлбэр, дархан, хатгамал, эсгий урлал, арьсан урлал) үндэсний хэв маяг хадгалсан жижиг бүтээл (бэлэг дурсгалын зүйл) хийж чаддаг болно.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

1.2.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ДҮРСЛЭХ ГЕОМЕТР

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДЗЗТ10.1.1.ҮД1. Сурагч огторгуй дах цэг, шулууныг ортогональ параллел проекцын аргаар дүрсэлж чаддаг болно.	ДЗЗТ10.1.1.ҮД1.Ш1. Цэгийг I квадрант ба I октантад дүрсэлдэг. ДЗЗТ10.1.1.ҮД1.Ш2. Онцгой байршилтай шулууныг ортогональ параллел проекцын аргаар I квадрант ба I октантад дүрсэлдэг. ДЗЗТ10.1.1.ҮД1.Ш3. Шулууныг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн хавтгайд дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
ДЗЗТ10.1.1.ҮД1.Ш1. Цэгийг I квадрант ба I октантад дүрсэлдэг.	Проекцын 3 хавтгайн систем, I квадрант ба I октантыг зурж дүрсэлдэг.	Проекцийн 3 хавтгайн системд координат өгч огторгуйд, проекцын хавтгайд, тэнхлэгт орших цэгүүдийг I квадрантад дүрс зургаар байгуулан дүрсэлдэг.	Проекцын 3 хавтгайд цэгийн проекцыг ортогональ параллел проекцын аргаар байгуулан дүрсэлдэг.	Өгөгдлийн дагуу цэгийн нэгдсэн проекцыг ортогональ параллел проекцын аргаар I квадрант ба I октантад зөв байгуулан зурж дүрсэлдэг.
ДЗЗТ10.1.1.ҮД1.Ш2. Онцгой байршилтай шулууныг ортогональ параллел проекцын аргаар I квадрант ба I октантад дүрсэлдэг.	2 цэгийг байгуулан, тэдгээрийг холбон хэрчим шулуун үүсгэн дүрсэлдэг.	Нүүрний, хэвтээ, хажуугийн түвшний шулуунуудыг байгуулан зурж дүрсэлдэг.	Хэвтээ, нүүрт, хажууд проекцлогч шулуунуудыг байгуулан зурж дүрсэлдэг.	Онцгой байршилтай шулууны проекц дүрслэлийг ортогональ параллел проекцын аргаар I октантад дүрсэлдэг.
ДЗЗТ10.1.1.ҮД1.Ш3. Шулууныг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн хавтгайд дүрсэлдэг.	Өгсөн координатын дагуу шулууны цэгүүдийг тооцоолон байгуулж дүрсэлдэг.	Шулууны проекцын дүрс зургийг байгуулан дүрсэлдэг.	Шулууны дүрс зургаас проекц дүрслэлийг байгуулан зурж дүрсэлдэг.	Өгөгдлийн дагуу шулууныг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн хавтгайд байршлыг тодорхойлон зурж дүрсэлдэг.

1.2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. ТЕХНИКИЙН ЗУРАГ ЗҮЙ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДЗЗТ.10.1.2.ҮД2. Сурагч зураг зүйн дүрэм стандартын дагуу геометр байгуулалт (эллипс, овал, овоид) болон техникийн эд ангийн тойм ба ажлын зургийг зурж чаддаг болно.	ДЗЗТ.10.1.2.ҮД2.Ш1. Эллипс, овал, овоидын муруй шугамыг геометр байгуулалтаар зурдаг.
		ДЗЗТ.10.1.2.ҮД2.Ш2. Зураг зүйн дүрэм стандартын дагуу техникийн эд ангийн тойм зургийг зурдаг.
		ДЗЗТ.10.1.2.ҮД2.Ш3. Зураг зүйн дүрэм стандартын дагуу техникийн эд ангийн ажлын зураг зурдаг.
2	ДЗЗТ.10.1.2.ҮД3. Сурагч техникийн эд ангийн холбоосыг огтлол, зүсэлт, хялбарчлалын аргуудаар стандартын дагуу зурж чаддаг болно.	ДЗЗТ.10.1.2.ҮД3. Ш4. Техникийн салдаг холбоосыг стандартын дагуу огтлол, зүсэлт хялбарчлалын аргаар зурдаг.
		ДЗЗТ.10.1.2.ҮД3.Ш5. Техникийн салдаггүй холбоосыг стандартын дагуу огтлол, зүсэлт хялбарчлалын аргаар зурдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Д33Т.10.1.2.ҮД2. Ш1. Эллипс, овал, овиодын муруй шугамыг геометр байгуулалтаар зурдаг.	Эллипс, овал, овиодын муруй байгуулах тэгш хэмийн тэнхлэг байгуулж тойрог зурдаг.	Тойргийг тэнцүү хэсэгт хувааж эллипс, овал, овиодын муруй байгуулах төвийн цэгүүдийг олж зурдаг.	Геометр байгуулалтын аргаар овал, овиодын муруйг байгуулж зурдаг.	Геометр байгуулалтын аргаар эллипс, овал, овиодын муруй шугамыг байгуулалтаар зурдаг.
Д33Т.10.1.2.ҮД2.Ш2. Зураг зүйн дүрэм стандартын дагуу техникийн эд ангийн тойм зургийг зурдаг.	Техникийн эд ангийн деталийн элементүүдийг тодорхойлж проекцын хавтгайг (тэгш өнцөгт, аксонометр проекцын тэнхлэг) зурдаг.	Техникийн эд ангийн деталийн хоорондын зайг тооцоолж оврын хэмжээгээр проекцын тэнхлэг дээр ерөнхийлөн дүрсэлдэг.	Техникийн эд ангийн элементүүдийн байршлыг тодорхойлж гадаад хэлбэр дүрсийг байгуулдаг.	Огтлол зүсэлтийн аргаар деталийн бүтэц, эд ангийн тойм зургийг зурдаг.
Д33Т.10.1.2.ҮД2.Ш3. Зураг зүйн дүрэм стандартын дагуу техникийн эд ангийн ажлын зураг зурдаг.	Техникийн дүрэм стандарт, масштабын дагуу техникийн эд ангийг проекцын хавтгайд тоймлон дүрсэлдэг.	Техникийн дүрэм стандартын дагуу техникийн эд ангийн элементүүдийг тодорхойлж дүрсэлдэг.	Техникийн эд ангийн дотоод бүтцийг огтлол, зүсэлттэйгээр харуулж дүрсэлдэг.	Техникийн эд ангийн эд ангийн ажлын зургийг ортогональ ба аксонометр проекцын аргаар зурдаг.
Д33Т.10.1.2.ҮД3. Ш4. Техникийн салдаг холбоосыг стандартын дагуу огтлол, зүсэлт хялбарчлалын аргаар зурдаг.	Техникийн салдаг холболтын деталийн элементүүдийг тодорхойлж проекцын хавтгайд тоймлон дүрсэлдэг.	Техникийн салдаг холболтын деталийн элементүүдийг стандарт тэмдэглэгээ ашиглан тооцоолдог.	Техникийн салдаг холболтыг стандарт тэмдэглэгээний дагуу тооцоолж зурдаг.	Техникийн салдаг холболтыг стандарт тэмдэглэгээний дагуу тооцоолж огтлол зүсэлттэйгээр харуулж зурдаг.
Д33Т.10.1.2.ҮД3.Ш5. Техникийн салдаггүй холбоосыг стандартын дагуу огтлол, зүсэлт хялбарчлалын аргаар зурдаг.	Техникийн салдаггүй холболтын деталийн элементүүдийг тодорхойлж проекцын хавтгайд тоймлон дүрсэлдэг.	Техникийн салдаггүй холболтын деталийн элементүүдийг стандарт тэмдэглэгээ ашиглан тооцоолдог.	Техникийн салдаггүй холболтыг стандарт тэмдэглэгээний дагуу тооцоолж зурдаг.	Техникийн салдаггүй холболтыг стандарт тэмдэглэгээний дагуу тооцоолж огтлол зүсэлттэйгээр харуулж зурдаг.

1.2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. ГРАФИК ДИЗАЙНЫ ҮНДЭС

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Д33Т.10.1.3.ҮД4. Сурагч график дизайны элементүүдийн онцлогийг, ялган таних замаар мэдээллийн тэмдэгт зохион зурж чаддаг болно.	Д33Т.10.1.3.ҮД4.Ш1. График дизайны элементүүдийн онцлогийг ялган таних замаар мэдээллийн тэмдэгт зохион бүтээдэг
2	Д33Т.10.1.3.ҮД5. Сурагч орчин үеийн брэнд, инновацыг таних замаар сурталчилгааны зурагт хуудас хийж чаддаг болно.	Д33Т.10.1.3.ҮД5.Ш2. Орчин үеийн брэнд дизайн, инновацын талаарх ойлголтоо бүтээгдэхүүний жишээгээр тайлбарладаг.
		Д33Т.10.1.3.ҮД5.Ш3. Орчин үеийн брэндийн, сурталчилгааны зурагт хуудас зохиож бүтээдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Д33Т.10.1.3.ҮД4.Ш1. График дизайны элементүүдийн онцлогийг ялган таних замаар мэдээллийн тэмдэгт зохион бүтээдэг.	График дизайны элементүүдийн онцлог ялгааг бүтээлийн жишээн дээр тайлбарладаг.	Хэрэглээг судалж мэдээллийн тэмдэгтийн санаагаа тодорхойлдог.	Мэдээллийн тэмдэгтийн дизайн санаагаа тойм зургийн аргаар дүрсэлдэг.	Мэдээллийн тэмдэгтийн дизайн загварыг зохион бүтээх аргууд (фото зургийн, эвлүүлэг, зүймэл урлаг) болон компьютерын зургийн программ ашиглан зохион бүтээдэг.
Д33Т.10.1.3.ҮД5.Ш2. Орчин үеийн брэнд дизайн, инновацын талаарх ойлголтоо бүтээгдэхүүний жишээгээр тайлбарладаг.	Орчин үеийн график дизайны төрлүүдийг нэрлэж ялгааг тайлбарладаг.	Орчин үеийн график дизайны бүтээлийг брэнд инновацитай холбож тайлбарладаг.	Орчин үеийн график дизайны бүтээлийг брэнд инновацитай холбож үндэсний ба олон улсын бүтээгдэхүүний жишээн дээр харьцуулж тайлбарладаг.	Брэнд инновацийг судалж график дизайны бүтээлийн санаа гаргаж тайлбарладаг.
Д33Т.10.1.3.ҮД5.Ш3. Орчин үеийн брэндийн сурталчилгааны зурагт хуудас зохиож бүтээдэг.	Орчин үеийн брэнд бүтээгдэхүүнийг судалгаа хийж тайлбарладаг.	Сонгосон брэнд бүтээгдэхүүний сурталчилгааны санаагаа тодорхойлж дүрсэлдэг.	Брэнд бүтээгдэхүүний сурталчилгааны зурагт хуудасны загварыг зурдаг. (гараар болон компьютерын зургийн программ)	Шинэ брэнд бүтээгдэхүүний сурталчилгааны зурагт хуудас зохиож бүтээдэг. (гараар болон компьютерын зургийн программ)

1.2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. ХУВЦАСНЫ ТЕХНОЛОГИ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДЗЗТ10.2.1.ҮД6. Сурагч мөртэй хувцасны суурь үлгэрийг байгуулж, загварчилж чаддаг болно.	ДЗЗТ10.2.1.ҮД6.Ш1. Загварын чиг хандлагад нийцүүлэн мөртэй хувцасны загвар зохиож зурдаг.
		ДЗЗТ10.2.1.ҮД6.Ш2. Биеэс хэмжээ авч тооцоолох аргаар (эсгүүр байгуулах аргачлал) мөртэй хувцасны суурь эсгүүрийг (М1:1, М1:4 хэмжээ) дарааллын дагуу байгуулдаг.
		ДЗЗТ10.2.1.ҮД6.Ш3. Мөртэй хувцасны эсгүүрийн зургийг загварт нийцүүлэн өөрчилж загварчилдаг.
2	ДЗЗТ10.2.1.ҮД7. Сурагч мөртэй хувцсыг технологи дарааллын дагуу эсгэж, оёж чаддаг болно.	ДЗЗТ10.2.1.ҮД7.Ш4. Мөртэй хувцсыг технологи дарааллын дагуу эсгэдэг.
		ДЗЗТ10.2.1.ҮД7.Ш5. Мөртэй хувцсыг технологи төлөвлөлтийн дагуу оёж, чимэглэдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДЗЗТ10.2.1.ҮД6.Ш1. Загварын чиг хандлагад нийцүүлэн мөртэй хувцасны загвар зохиож зурдаг.	Орчин үеийн загварын трэнд чиг хандлагыг тайлбарладаг.	Орчин үеийн хувцасны загварын трэнд чиг хандлагыг коллаж, постер, зураг дүрслэл ашиглан харуулдаг.	Хувцасны зохиомжийн элементүүд болон зохион бүтээх аргуудыг (бүтцийн шинжилгээний) ашиглан мөртэй хувцасны загварын шинэ шийдэл санаа гаргадаг.	Загварын чиг хандлагад нийцүүлэн мөртэй хувцасны загвар зохиож зурдаг.
ДЗЗТ10.2.1.ҮД6.Ш2. Биеэс хэмжээ авч тооцоолох аргаар (эсгүүр байгуулах аргачлал) мөртэй хувцасны суурь эсгүүрийг (М1:1, М1:4 хэмжээ) дарааллын дагуу байгуулдаг.	Хүний биеийн хэмжил зүйн цэгүүдийг ашиглан биеэс хэмжээг (мөртэй хувцас) аргачлалын дагуу хэмждэг.	Биеийн хэмжээгээр тооцоолох аргаар эсгүүрийн тор байгуулдаг.	Биеийн хэмжээгээр тооцоолох аргаар бүрдэл хэсгүүдийн (ар, энгэр, зах, ханцуй) эсгүүр байгуулдаг.	Биеийн хэмжээгээр тооцоолох аргаар мөртэй хувцасны эсгүүр (М1:1, М1:4 хэмжээ) байгуулдаг.
ДЗЗТ10.2.1.ҮД6.Ш3. Мөртэй хувцасны эсгүүрийн зургийг загварт нийцүүлэн өөрчилж загварчилдаг.	Мөртэй хувцасны загварын онцлогт тохирсон загварчилгааны аргыг сонгодог.	Мөртэй хувцасны бүрдэл хэсгүүдийг загварчилгааны аргуудаар өөрчилж загварчилдаг.	Сонгосон загварын онцлогт нийцүүлэн мөртэй хувцсыг өөрчилж загварчилдаг.	Сонгосон загварт нийцсэн мөртэй хувцасны шинэ үлгэрийг зохион бүтээдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Д33Т10.2.1.ҮД7.Ш4. Мөртэй хувцсыг технологи дарааллын дагуу эсгэдэг.	Мөртэй хувцасны зориулалт, загварын онцлогт (өдөр тутам, гоёлын, гэрийн г.м) нийцүүлэн даавууг сонгодог.	Эдлэлийн урт, бүрдэл хэсгийг (загвар, хийц, даавууны өргөн, хээ) харьцуулан тодорхойлж даавууны орцыг тооцож эсгүүрт бэлтгэдэг.	Мөртэй хувцасны үлгэрийг (бэлэн болон байгуулсан) материалын үндсэн утасны чиглэлийн дагуу байрлуулж оёдлын хэмжээг тооцоолж тэмдэглэдэг.	Мөртэй хувцасны бүрдэл хэсгүүдийг эсгэдэг.
Д33Т10.2.1.ҮД7.Ш5. Мөртэй хувцсыг технологи төлөвлөлтийн дагуу оёж, чимэглэдэг.	Оёдлын технологи ажилбарын дарааллыг төлөвлөдөг.	Мөртэй хувцасны бүрдэл хэсгүүдийг оёж бэлтгэдэг. (чийг дулааны ажиллагаа, энгэр, ар, зах, ханцуйг оёж бэлтгэх)	Мөртэй хувцсыг төлөвлөсөн технологи ажилбарын дарааллын дагуу бүрдэл хэсгүүдийг нэгтгэж оёдог.	Сонгосон мөртэй хувцасны онцлогийг тодотгож чимэглэдэг.

1.2.5. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 5. ХООЛНЫ ТЕХНОЛОГИ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Д33Т10.2.2.ҮД8. Сурагч гар болон цахилгаан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан зуурмагийн төрлийг сонгож төрөл бүрийн гурилан бүтээгдэхүүн хийж чаддаг болно.	Д33Т10.2.2.ҮД8. Ш1. Гурилын зэрэглэл, тэжээллэг чанарыг тодорхойлох замаар гурилан бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэдэг.
		Д33Т10.2.2.ҮД8.Ш2. Гар болон цахилгаан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан зуурмагийн төрлийг сонгож гурилан бүтээгдэхүүнийг (амтат бялуу, нарийн боов, жигнэмэг) технологи дарааллын дагуу хийж, чимэглэдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Д33Т10.2.2.ҮД8. Ш1. Гурилын зэрэглэл, тэжээллэг чанарыг тодорхойлох замаар гурилан бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэдэг.	Үр тарианы төрөл ангилал, бүтцийг тайлбарладаг.	Гурилын төрөл ангилал, зэрэглэлийг харьцуулан тайлбарладаг.	Гурилын тэжээллэг чанарыг харьцуулан тайлбарладаг.	Гурилын найрлага, тэжээллэг чанараар нь гурилан бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэдэг.
Д33Т10.2.2.ҮД8.Ш2. Гар болон цахилгаан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан зуурмагийн төрлийг сонгож гурилан бүтээгдэхүүнийг (амтат бялуу, нарийн боов, жигнэмэг) технологи дарааллын дагуу хийж, чимэглэдэг.	Гурилан бүтээгдэхүүний (амтат бялуу, нарийн боов, жигнэмэг) жорыг судалж орцыг хэмжээгээр тооцоолдог.	Гар болон цахилгаан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан зуурмагийн төрлийг орц, найрлага, технологи дарааллыг мөрдөж төрөл бүрийн зуурмаг бэлтгэдэг.	Гар болон цахилгаан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан зуурмагийн төрлийг сонгож гурилан бүтээгдэхүүнийг (амтат бялуу, нарийн боов, жигнэмэг) ААД баримтлан технологи дарааллын дагуу хийдэг.	Төрөл бүрийн гурилан бүтээгдэхүүнийг (амтат бялуу, нарийн боов, жигнэмэг) нарийн боовны багаж хэрэгслүүд ашиглан тохирсон аргаар чимэглэдэг.

1.2.6. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 6. МЕХАНИК БА ЭЛЕКТРОНИК

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДЗЗТ10.2.3.ҮД9. Сурагч техникийн эд ангиудын кинематик схемийг уншиж, хөдөлгөөний зарчмыг тайлбарлаж чаддаг болно.	ДЗЗТ10.2.3.ҮД9.Ш1. Кинематик схем дэх тэмдэглэгээг унших замаар техникийн нэгж угсрааны бүтэц, эд ангиудыг тодорхойлдог.
		ДЗЗТ10.2.3.ҮД9.Ш2. Нэгж угсрааны хөдөлгөөн ба шилжилтийн зарчмыг механикийн онолоор тодорхойлдог.
2	ДЗЗТ10.2.3.ҮД10. Сурагч цахилгаан үүсгүүрийн төрөл болон электроникийн энгийн элементүүд (хагас дамжуулагч, диод, эсэргүүцэл) хийцийн материалын хэрэгцээг тодорхойлж, бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгож чаддаг болно.	ДЗЗТ10.2.3.ҮД10.Ш3. Цахилгаан үүсгүүр болон электроникийн элемент хагас дамжуулагч, диодын ажиллах зарчим төрөл ангиллыг судлах замаар бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгодог.
		ДЗЗТ10.2.3.ҮД10.Ш4. Хийцийн материалын төрөл ангиллыг тодорхойлж бүтээлд нийцүүлэн сонгодог.
3	ДЗЗТ10.2.3.ҮД11. Сурагч электроникийн энгийн элементүүд ашиглан техникийн хөдөлгөөнт бүтээл хийж, бүтээлийн ажиллагаа, хөдөлгөөнд тохиргоо хийж чаддаг болно.	ДЗЗТ10.2.3.ҮД11.Ш5. Хөдөлгөөнт бүтээлийн загварын санаагаа эд анги, нэгж угсрааны ажлын зураг, электроникийн ажиллах зарчмын схем зургаар илэрхийлдэг.
		ДЗЗТ10.2.3.ҮД11.Ш6. Хөдөлгөөнт бүтээлээ технологийн дагуу хийж гүйцэтгэдэг.
		ДЗЗТ10.2.3.ҮД11.Ш7. Хөдөлгөөнт бүтээлийн ажиллагаа, хөдөлгөөнд тохиргоо хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДЗЗТ10.2.3.ҮД9.Ш1. Кинематик схем дэх тэмдэглэгээг унших замаар техникийн нэгж угсрааны бүтэц, эд ангиудыг тодорхойлдог.	Эд ангиудын нэгж угсрааны кинематик схем дүрслэл таньдаг.	Нэгж угсрааны эд ангийг кинематик схем зургаас нэрлэдэг.	Нэгж угсрааны бүтцийг кинематик схемийн жишээн тайлбарладаг.	Нэгж угсрааны эд ангийн ажиллах зарчмыг кинематик схемийн жишээн дээр тайлбарладаг.
ДЗЗТ10.2.3.ҮД9.Ш2. Нэгж угсрааны хөдөлгөөн ба шилжилтийн зарчмыг механикийн онолоор тодорхойлдог.	Механик хөдөлгөөний шилжилтийг тодорхойлдог.	Механик хөдөлгөөний төрөл ангиллыг тодорхойлдог.	Хүч хожих механизмуудын ажиллах зарчмыг тодорхойлдог.	Хүч хожих хөшүүргийн механизмын ажиллах зарчим, биетийн хүндийн төвийг тодорхойлдог.
ДЗЗТ10.2.3.ҮД10.Ш3. Цахилгаан үүсгүүр болон электроникийн элемент хагас дамжуулагч, диодын ажиллах зарчим төрөл ангиллыг судлах замаар бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгодог.	Хагас дамжуулагч, цахилгаан үүсгүүрийн төрлүүдийг нэрлэдэг.	Цахилгаан үүсгүүр, хагас дамжуулагчийн үүрэг төрөл, тогтмол болон хувьсах гүйдлийн ялгааг тодорхойлдог.	Хагас дамжуулагч диодын бүтэц ажиллах зарчмыг тодорхойлдог.	Бүтээлийн онцлогт нийцүүлэн цахилгаан үүсгүүр болон электроникийн элемент хагас дамжуулагчийг сонгодог.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

ДЗЗТ10.2.3.ҮД10.Ш4. Хийцийн материалын төрөл ангиллыг тодорхойлж бүтээлд нийцүүлэн сонгодог.	Хийцийн материалын төрөл ангиллыг эдлэлийн жишээгээр тайлбарладаг.	Мод хломерийн хольцтой композит материал болон нано бүтэцтэй материалын шинж чанарыг тодорхойлдог.	Хийцийн материалын шинж чанарыг (шилбэний бат бэх, зөвшөөрөгдөх хүч) тодорхойлдог.	Хийцийн материалын физик шинж чанарыг тодорхойлж хийх эдлэлд нийцүүлэн сонгодог.
ДЗЗТ10.2.3.ҮД11.Ш5. Хөдөлгөөнт бүтээлийн загварын санаагаа эд анги, нэгж угсрааны ажлын зураг, электроникийн ажиллах зарчмын схем зургаар илэрхийлдэг.	Зохион бүтээх хөдөлгөөнт бүтээлийн тойм зургийг зурдаг.	Зохион бүтээх хөдөлгөөнт бүтээлийн нэгж угсрааны ажлын зураг зурдаг.	Зохион бүтээх хөдөлгөөнт бүтээлд ашиглах электроникийн ажиллах зарчмын схем бүдүүвчийг зурдаг.	Зохион бүтээх хөдөлгөөнт бүтээлийн нэгж угсрааны зураг, электроникийн схемийг стандартын дагуу зурдаг.
ДЗЗТ10.2.3.ҮД11.Ш6. Хөдөлгөөнт бүтээлээ технологийн дагуу хийж гүйцэтгэдэг.	Хөдөлгөөнт бүтээлд ашиглагдах хийцийн эд ангиуд, электрон элементүүдын жагсаалт гаргадаг.	Хөдөлгөөнт бүтээлийн нэгж угсрааны хийцийн эд ангиудыг технологийн дагуу ААД баримтлан хийдэг.	Хөдөлгөөнт бүтээлийн электрон элементүүдийг схемийн дагуу угсарч гагнах технологииор ААД баримтлан хийдэг.	Хийцийн эд анги, электрон элементийг холбож угсрах технологийн дагуу хөдөлгөөнт бүтээл хийдэг.
ДЗЗТ10.2.3.ҮД11.Ш7. Хөдөлгөөнт бүтээлийн ажиллагаа, хөдөлгөөнд тохиргоо хийдэг.	Хөдөлгөөнт бүтээлийн эд анги хийцэд үнэлгээ өгдөг.	Электроникийн схемийн дагуу угсарсан байдлыг шалгаж, үнэлгээ өгдөг.	Хөдөлгөөнт бүтээлийн ажиллах зарчмыг туршиж үнэлгээ өгдөг.	Үнэлгээнд үндэслэн хөдөлгөөнт бүтээлийг засан сайжруулдаг.

1.2.7. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 7. УЛАМЖЛАЛТ ТЕХНОЛОГИ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДЗЗТ10.2.4.ҮД12. Сурагч уламжлалт гар урлалын технолоииор (баримал, шуумал, сийлбэр, дархан, хатгамал, эсгий урлал, арьсан урлал) үндэсний хэв маяг хадгалсан жижиг бүтээл (бэлэг дурсгалын зүйл) хийж чаддаг болно.	ДЗЗТ10.2.4.ҮД12.Ш1. Уламжлалт технологийн онцлог, өвөрмөц шинж чанарыг ахуйн хэрэглээний эд зүйлсийн жишээгээр тайлбарладаг.
		ДЗЗТ10.2.4.ҮД12.Ш2. Үндэсний уламжлалт гар урлалын технолоииос (баримал, шуумал, сийлбэр, дархан, хатгамал, эсгий урлал, арьсан урлал) сонгож судлах замаар хийх жижиг бүтээлийн (бэлэг дурсгалын зүйл) загварыг гаргадаг.
		ДЗЗТ10.2.4.ҮД12.Ш3. Уламжлалт гар урлалын технолоииор үндэсний хэв маяг хадгалсан жижиг бүтээл (бэлэг дурсгалын зүйл) хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Д33Т10.2.4.ҮД12. Ш1. Уламжлалт технологийн онцлог, өвөрмөц шинж чанарыг ахуйн хэрэглээний эд зүйлсийн жишээгээр тайлбарладаг.	Үндэсний уламжлалт арга технологийг эдлэлийн жишээгээр таньж нэрлэдэг.	Үндэсний уламжлалт технологиор хийгдсэн эдлэлийн онцлогийг харьцуулан тайлбарладаг.	Үндэсний уламжлалт технологиор хийгдсэн эдлэлийг хийх арга, технологи дарааллыг жишээгээр тайлбарладаг.	Үндэсний уламжлалт технологиор хийгдсэн бүтээлийн өвөрмөц шинж чанарыг тодорхойлж тайлбарладаг.
Д33Т10.2.4.ҮД12. Ш2. Үндэсний уламжлалт гар урлалын технологиос (баримал, шуумал, сийлбэр, дархан, хатгамал, эсгий урлал, арьсан урлал) сонгож судлах замаар хийх жижиг бүтээлийн (бэлэг дурсгалын зүйл) загварыг гаргадаг.	Үндэсний уламжлалт гар урлалын технологиор хийх эдлэлээ тодорхойлдог.	Судалгааны аргуудыг ашиглан сонгосон эдлэлийн дизайн, арга технологийг судалж тайлбарладаг.	Судалгаанд үндэслэн үндэсний хэв маяг тусгасан загварыг хувилбартайгаар зурдаг.	Үндэсний хэв маяг хадгалсан загварыг сонгож ажлын зургийг зурдаг.
Д33Т10.2.4.ҮД12.Ш3 Уламжлалт гар урлалын технологиор үндэсний хэв маяг хадгалсан жижиг бүтээл (бэлэг дурсгалын зүйл) хийдэг.	Сонгосон загварыг хийх үйл явц, технологи дарааллыг төлөвлөдөг.	Уламжлалт гар урлалаар хийх бүтээлийн материал, арга технологийг туршдаг.	Төлөвлөлтийн дагуу технологи ажилбарыг гүйцэтгэдэг.	Уламжлалт гар урлалын технологиор үндэсний хэв маяг хадгалсан жижиг бүтээл (бэлэг дурсгалын зүйл) хийдэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. XI АНГИ

2.1. XI АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	11.1.1а. Түвшний болон проекцлогч байршилтай хавтгайг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн системд дүрслэх 11.1.б. Проекцлогч байршилтай хавтгайг хавтгайн мөрөөр эргүүлэх аргаар бодит хэмжээг тодорхойлох	Дүрслэх геометр	Д33Т11.1.1.ҮД1. Сурагч хавтгайг (түвшний ба проекцлогч) проекцын нэгдсэн системд дүрсэлж, хавтгайн бодит хэмжээг тодорхойлдог болно.
2	11.1.2а. Эдлэлийн угсрааны зургаас деталийн онцлогийг ялган таньж деталийг нэрлэх, дугаарлах, салган дүрслэх 11.1.2б. Өгсөн эдлэлийн бүдүүвч зургийг томьёолсон тэмдэглэгээг ялган таних замаар дүрслэх	Техникийн зураг зүй	Д33Т11.1.2.ҮД2. Сурагч эдлэлийн угсрааны болон бүдүүвч зургийг уншиж дүрсэлдэг болно.
3	11.1.3а. Дэлхийн болон Монголын уран барилгын түүхэн хөгжил хэрэгцээ, онцлогийг ялган таньж, уран барилгын дурсгалыг тайлбарлан ярих 11.1.3б. Өгсөн барилгын ерөнхий зургийг баримт бичгийн нормативын хэрэгцээг танин барилгын орчинг нь төлөвлөн зурах 11.1.3в. Барилгын хийцийн элементүүдийн томьёолсон тэмдэглэгээг ялган таньж, хана, хаалга, цонх, шат зэрэг элементүүдийг дүрслэх 11.1.3г. Барилгын фасад, байгуулалт, хажуугийн зүсэлтийн проекц байгуулах аргаар төлөвлөн зурах	Барилгын зураг зүй	Д33Т11.1.3.ҮД3. Сурагч барилгын хийцийн элементүүдийн томьёолсон тэмдэглэгээг барилгын зургийн үндсэн дүрслэл (фасад, план, зүсэлт) –ийг төлөвлөн зурж чаддаг болно.
4	11.1.4а.3 хэмжээст дүрс бүтээх зарчмаар орон зайн зохиомж хийх 11.1.4б. Оршин буй газрынхаа гадна орчны барилга, зам, талбайн орон зайн хэрэгцээг илрүүлэх замаар ландшафтын макет бүтээх	Ландшафт дизайны үндэс	Д33Т11.1.4.ҮД4. Сурагч орчныхоо барилга зам талбайн план зургийг төлөвлөн зурж макет загвар хийж чаддаг болно.
5	11.2.1а. Монгол хувцасны үүсэл хөгжил, төрөл ангилал, онцлог, бэлгэдлийг жишээгээр үзүүлж тайлбарлах 11.2.1б. Үндэсний загвартай орчин үеийн хувцасны загварын шинэ санаа шийдлийг гол объектийн арга ашиглан зохиомжлон бүтээх 11.2.1в. Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулах 11.2.1г. Монгол дээл хувцас эсгэх уламжлалт арга технологийг хэрэглэн эсгүүр байгуулах 11.2.1д. Үндэсний загвартай хувцсыг орчин үеийн эсгүүр, загварчилгааны аргаар эсгэх, загварчлах	Хувцасны технологи	Д33Т11.2.1.ҮД5. Сурагч үндэсний загвартай орчин үеийн хувцасны суурь үлгэрийг байгуулж, загварчилж чаддаг болно.
	11.2.1е. Монгол хувцас эсгэх, оёх технологи дарааллыг загварын онцлогт тохируулан төлөвлөх 11.2.1ж. Монгол үндэсний хувцсыг уламжлалт ба орчин үеийн арга технологийг хослуулан эсгэх, оёх, чимэглэх		Д33Т11.2.1.ҮД6. Сурагч үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи дарааллын дагуу эсгэж, оёж чаддаг болно.

6	11.2.2а. Монгол үндэсний болон бусад үндэстний хоол, хүнсний хэрэглээний нийтлэг ба ялгаатай тал, онцлогийг харьцуулах 11.2.2б. Амьтны ба далайн гаралтай бүтээгдэхүүний (малын мах, гахай, тахиа, загас, дайвар бүтээгдэхүүн)-ийг найрлага, шимт бодис, илчлэг чанар, хадгалалт, хэрэглээгээр нь харьцуулах 11.2.2в. Мах, махан бүтээгдэхүүн, загасанд заавар, аргачлалын дагуу анхан шатны боловсруулалт хийх	Хоолны технологи	ДЗЗТ11.2.2.ҮД7. Сурагч мах махан бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийх замаар төрөл бүрийн хоол хийж чаддаг болно.
7	11.2.3а. Механик дамжуулгын хялбар тооцоолол хийхдээ мөчүүдийн хөдөлгөөний байрлалын план байгуулах аргаар шилжилт, хурд, хүчийг тодорхойлох 11.2.3б. Электрон ба механик мэдрэгчийн төрөл, бүтэц, үүргийг харьцуулах аргаар ажиллах зарчмыг мэдэх.	Механик электроник	ДЗЗТ11.2.3.ҮД8. Сурагч механик, шүдэт, үрэлтэд дамжуулгын ажиллах зарчмыг судалж, мөчүүдийн хөдөлгөөний байрлалын план байгуулах аргаар эргэлтийн хурд, шилжилт, хүчийг тооцоолон бодож чаддаг болно.
	11.2.3б. Электрон ба механик мэдрэгчийн төрөл, бүтэц, үүргийг харьцуулах аргаар ажиллах зарчмыг мэдэх 11.2.3в. Цахилгаан дохионы ажиллах зарчмыг судлахдаа аналог ба тоон системийн ялгааг тогтоон, хугацаанаас хамаарсан үелэн давтагдах шинж чанарыг тайлбарлах		ДЗЗТ11.2.3.ҮД9. Сурагч цахилгаан дохио, мэдрэгчийн (электрон ба механик) ажиллах зарчим хэрэглээг тайлбарлаж чаддаг болно.
	11.2.3г. Тоон электроникийн зарчмыг тодорхойлохдоо, тооллын системийн төрөл зүй тогтлыг олох замаар микросхем ашиглан турших 11.2.3е. Электрон хэлхээний ажиллах зарчмын схемийг Proteus программ ашиглан зурж, кибр орчинд турших		ДЗЗТ11.2.3.ҮД10. Сурагч электрон схем загварчлалын Proteus программ дээр энгийн электрон схем, тоон электроникийн зарчмыг (интеграл таймер 555) микросхем ашиглан хийсвэр орчинд ажиллуулж туршдаг болно.
	11.2.3д. Нийлмэл материал, электрон элементүүдийг төрөлжүүлэн ангилж, техникийн бүтээл хийхдээ зөв сонгох 11.2.3ж. Техникийн автомат бүтээл хийхдээ төслийн аргаар үйл ажиллагаагаа төлөвлөж, технологийн зөв дараалал баримтлан зохиомжлон бүтээх.		ДЗЗТ11.2.3.ҮД11. Сурагч нийлмэл материал, электроникийн энгийн элементүүд ашиглан төслийн аргаар техникийн автомат бүтээл хийж чаддаг болно.
	11.2.3з. Техникийн автомат бүтээлийн ажиллагааг шалгахдаа электрон хийцүүд болон нэгж угсрааны холболтын схемийг ашиглан хянах замаар тохиргоо хийх		ДЗЗТ11.2.3.ҮД12. Сурагч хийсэн автомат бүтээлийнхээ ажиллагаа, хөдөлгөөнд (механик, электроникийн) тохиргоо хийж чаддаг болно.
8	11.2.4а. Үндэсний уламжлалт технологи ашиглан хийх бүтээлийн шинэ загвар зохиох 11.2.4б. Уран дархан, сийлбэр, уран хатгамал, зоос ширээ гэх мэт уламжлалт гар урлалын технологийг ашиглан бүтээл урлах	Уламжлалт технологи	ДЗЗТ11.2.4.ҮД13. Сурагч уламжлалт гар урлалын технологиор (уран дархан, уран хатгамал, зоос ширээ) бүтээл хийж чаддаг болно.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

2.2.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ДҮРСЛЭХ ГЕОМЕТР

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Д33Т11.1.1.ҮД1. Сурагч хавтгайг (түвшний ба проекцлогч) проекцын нэгдсэн системд дүрсэлж, хавтгайн бодит хэмжээг тодорхойлдог болно.	Д33Т11.1.1.ҮД1.Ш1. Түвшний хавтгайг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн системд байгуулж дүрсэлдэг.
		Д33Т11.1.1.ҮД1.Ш2. Проекцлогч хавтгайг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн системд байгуулж дүрсэлдэг.
		Д33Т11.1.1.ҮД1.Ш3. Проекцлогч байршилтай хавтгайн бодит хэмжээг мөрөөр эргүүлэх аргаар байгуулан тодорхойлдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Д33Т11.1.1.ҮД1.Ш1. Түвшний хавтгайг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн системд байгуулж дүрсэлдэг.	Хавтгай дүрс өөртэйгээ параллел проекцын хавтгайдаа талбайн хэмжээгээр проекцлогддог инвариант чанарыг ойлгон зурж дүрсэлдэг.	Хэвтээ, нүүрний, хажуугийн түвшний байршилтай хавтгайг I квадрантад дүрс зургаар байгуулан дүрсэлдэг.	Хэвтээ, нүүрний, хажуугийн түвшний байршилтай хавтгайн байршлыг тодорхойлон, зурж дүрсэлдэг.	Өгөгдлийн дагуу түвшний хавтгайг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн системд байгуулан дүрсэлдэг.
Д33Т11.1.1.ҮД1.Ш2. Проекцлогч хавтгайг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн системд байгуулж дүрсэлдэг.	Хавтгай дүрс өөртэйгээ перпендикуляр проекцын хавтгайдаа шулуун болж проекцлогддог инвариант чанарыг ойлгон зурж дүрсэлдэг.	Нүүрт, хэвтээд, хажууд проекцлогч байршилтай хавтгайг I квадрантад дүрс зургаар байгуулан дүрсэлдэг.	Нүүрт, хэвтээд, хажууд проекцлогч байршилтай хавтгайг байршлыг тодорхойлон, зурж дүрсэлдэг.	Өгөгдлийн дагуу проекцлогч хавтгайг ортогональ параллел проекцын аргаар проекцын нэгдсэн системд байгуулан дүрсэлдэг.
Д33Т11.1.1.ҮД1.Ш3. Проекцлогч байршилтай хавтгайн бодит хэмжээг мөрөөр эргүүлэх аргаар байгуулан тодорхойлдог.	Проекцлогч байршилтай хавтгайн аль ч проекц талбайн хэмжээгээр проекцлогддоггүйг танин мэдэж тодорхойлдог.	Проекцын нэмэлт хавтгайг эргүүлэн проекцын аль ч 1 хавтгайтай параллел болгож талбайн бодит хэмжээгээрээ проекцлогддогийг тайлбарлан тодорхойлдог.	Проекцлогч байршилтай хавтгайн бодит хэмжээг хавтгай солих аргаар байгуулан тодорхойлдог.	Проекцлогч байршилтай хавтгайн бодит хэмжээг мөрөөр эргүүлэх аргаар байгуулан тодорхойлдог.

2.2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. ТЕХНИКИЙН ЗУРАГ ЗҮЙ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Д33Т11.1.2.ҮД2. Сурагч эдлэлийн угсрааны болон бүдүүвч зургийг уншиж дүрсэлдэг болно.	Д33Т11.1.2.ҮД2. Ш1. Сурагч эдлэлийн угсрааны зургийг уншиж деталийн онцлогийг нэрлэж, дугаарлан, ялган таньж салган дүрсэлдэг.
		Д33Т11.1.2.ҮД2.Ш2. Сурагч эдлэлийн бүдүүвч зургийн томьёолсон тэмдэглэгээг уншиж, нэрлэн, ялган таньж, дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Д33Т11.1.2.ҮД2.Ш1. Сурагч эдлэлийн угсрааны зургийг уншиж деталийн онцлогийг нэрлэж, дугаарлан, ялган таньж салган дүрсэлдэг.	Эдлэлийн угсрааны зургийг уншиж тайлбарладаг.	Эдлэлийн угсраа, деталийн онцлогийг огтлол зүсэлттэйгээр 2 хэмжээст байдлаар дүрсэлдэг.	Эдлэлийн угсраа, деталийн онцлогийг огтлол зүсэлттэйгээр 3 хэмжээст байдлаар дүрсэлдэг.	Эдлэлийн угсрааны болон деталийн эд ангийг салган огтлол зүсэлттэйгээр 2 ба 3 хэмжээст байдлаар дүрсэлдэг.
Д33Т11.1.2.ҮД2.Ш2. Сурагч эдлэлийн бүдүүвч зургийн томьёолсон тэмдэглэгээг уншиж, нэрлэн, ялган таньж, дүрсэлдэг.	Эдлэлийн бүдүүвч зургийн томьёолсон тэмдэглэгээг ялган таньж нэрлэдэг.	Эдлэлийн бүдүүвч зургийг томьёолсон тэмдэглэгээний хэрэглээг тайлбарладаг.	Эдлэлийн бүдүүвч зургийг томьёолсон тэмдэглэгээ (хөдөлгөөн дамжуулах харилцан үйлчлэлийг харуулсан байдлаар)-ээр дүрсэлдэг.	Эдлэлийн бүдүүвч зургийг томьёолсон тэмдэглэгээ (техникийн хөдөлгөөн дамжуулах голуудыг дугаарлаж)-ээр дүрсэлдэг.

2.2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. БАРИЛГЫН ЗУРАГ ЗҮЙ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Д33Т11.1.3.ҮД3. Сурагч барилгын хийцийн элементүүдийн томьёолсон тэмдэглэгээгээр барилгын зургийн үндсэн дүрслэл (фасад, план, зүсэлт) –ийг төлөвлөн зурж чаддаг болно.	Д33Т11.1.3.ҮД3.Ш1. Дэлхийн болон Монголын уран барилгын түүхэн хөгжил, онцлогийг жишээгээр тайлбарладаг.
		Д33Т11.1.3.ҮД3.Ш2. Барилгын ерөнхий зургийг баримт бичиг норматив хэрэгцээнд нийцүүлэн барилгын орчинг төлөвлөн зурдаг.
		Д33Т11.1.3.ҮД3.Ш3. Барилгын хийцийн элементүүдийн томьёолсон тэмдэглэгээг ялган таньж, хана, хаалга, цонх, шат зэрэг элементүүдийг дүрсэлдэг.
		Д33Т11.1.3.ҮД3.Ш4. Барилгын фасад, байгуулалт, хажуугийн зүсэлтийн проекц байгуулах аргаар төлөвлөн зурдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн хүрэх түвшин			
	I	II	III	IV
Д33Т11.1.3.ҮД3.Ш1. Дэлхийн болон Монголын уран барилгын түүхэн хөгжил, онцлогийг жишээгээр тайлбарладаг.	Барилгын түүхэн хөгжлийг судалж онцлогийг тодорхойлж тайлбарладаг.	Барилгын хийц загварын хөгжлийг эртний болон сонгодог барилгын жишээн дээр тайлбарладаг.	Барилгын хийц загварын онцлогийг үндэсний уран барилгын жишээн дээр тайлбарладаг.	Орчин үеийн барилгын хийц загварыг барилгын түүхэн хөгжилтэй холбож тайлбарладаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Д33Т11.1.3.ҮД3.Ш2. Барилгын ерөнхий зургийг баримт бичиг норматив хэрэгцээнд нийцүүлэн барилгын орчинг төлөвлөн зурдаг.	Барилгын ерөнхий загвар зургийн баримт бичгийг судлан норматив хэмжээг судалж тайлбарладаг.	Барилгын ерөнхий загвар зургийн норматив (0,7га) хэмжээнд нийцүүлэн тооцоолж талбайн хэмжээг тодорхойлдог.	Барилгын ерөнхий загвар зургийн норматив хэмжээнд нийцсэн барилгын орчны байршлыг төлөвлөж тоймлон дүрсэлдэг.	Барилгын ерөнхий зургийг баримт бичиг норматив хэрэгцээнд нийцүүлэн барилгын орчинг төлөвлөн зурдаг.
Д33Т11.1.3.ҮД3.Ш3 Барилгын хийцийн элементүүдийн томьёолсон тэмдэглэгээг ялган таньж, хана, хаалга, цонх, шат зэрэг элементүүдийг дүрсэлдэг.	Барилгын хийцийн элементүүдийн томьёолсон тэмдэглэгээг ялган таньж тайлбарладаг.	Барилгын хийцийн элементүүдийн томьёолсон тэмдэглэгээгээр хана, хаалгыг ялган зурж дүрсэлдэг.	Барилгын хийцийн элементүүдийн томьёолсон тэмдэглэгээгээр цонх, шатыг зурж дүрсэлдэг.	Барилгын хийцийн элементүүдийн томьёолсон тэмдэглэгээгээр ашиглан план зургийг төлөвлөн (хана,хаалга,цонх, шат) зурдаг.
Д33Т11.1.3.ҮД3.Ш4. Барилгын фасад, байгуулалт, хажуугийн зүсэлтийн проекц байгуулах аргаар төлөвлөн зурдаг.	Барилгын зургийг уншиж тайлбарладаг.	Барилгын фасадыг, проекц дүрслэлийн аргаар төлөвлөн зурдаг.	Барилгын фасадыг хажуугийн зүсэлтээр проекцын хавтгай дээр дүрсэлдэг.	Барилгын фасад байгуулалтыг босоо ба хэвтээ зүсэлтээр проекцын хавтгай дээр төлөвлөн зурдаг.

2.2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. ЛАНДШАФТ ДИЗАЙНЫ ҮНДЭС

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Д33Т11.1.4.ҮД4. Сурагч орчныхоо барилга зам талбайн план зургийг төлөвлөн зурж макет загвар хийж чаддаг болно.	Д33Т111.4.ҮД4.Ш1. 3 хэмжээст дүрс бүтээх зарчмаар орон зайн зохиомж хийдэг.
		Д33Т11.1.4.ҮД4.Ш2. Орчныхоо зам талбайн план зураг төлөвлөн зурах замаар макет загвар хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Д33Т111.4.ҮД4.Ш1. 3 хэмжээст дүрс бүтээх зарчмаар орон зайн зохиомж хийдэг.	3 хэмжээст зохиомж хийх аргуудыг судалж хийх арга барилаа тайлбарладаг.	3 хэмжээст бүтээхдээ нугалбарт аргаар дүрсээ тооцоолон зурж орон зайт зохиомж бүтээдэг.	3 хэмжээст бүтээхдээ хавтгайг зүсэлттэйгээр зохиомжлон дүрсээ товойлгох аргаар тооцоолон зурж орон зайт зохиомж бүтээдэг.	3 хэмжээст бүтээхдээ зохиомжын (эскиз хийх, эзлэхүүнт, орон зайт, хөдөлгөөнт) аргуудыг ашиглан орон зайт зохиомж төлөвлөн бүтээдэг.
Д33Т11.1.4.ҮД4.Ш2. Орчныхоо зам талбайн план зураг төлөвлөн зурах замаар макет загвар хийдэг.	Орчныхоо зам талбайг судлан хэрэгцээг илрүүлж ландшафтын тойм зураг зурдаг.	Барилгын макет загвар хийхдээ төсөлт ажлын төлөвлөгөө боловсруулж багаж материалаа сонгон туршиж хөгжүүлдэг.	Барилгын макет загвар хийхдээ масштаблан багасгах аргаар деталь эд ангиудын макет загвар хийдэг.	Барилгын макет загвар хийхдээ төлөвлөлтийн дагуу барилгын орон зайт биет макет загварыг зохион бүтээдэг.

2.2.5. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 5. ХУВЦАСНЫ ТЕХНОЛОГИ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Д33Т11.2.1.ҮД5. Сурагч үндэсний загвартай орчин үеийн хувцасны суурь үлгэрийг байгуулж, загварчилж чаддаг болно.	Д33Т11.2.1.ҮД5.Ш1. Монгол дээлийн суурь үлгэрийг загварчилгааны аргуудаар өөрчилж загварчилдаг.
		Д33Т11.2.1.ҮД5.Ш2. Мөртэй хувцасны суурь үлгэрийг үндэсний хэв маяг, хэлбэрт оруулан өөрчилж загварчилдаг.
2	Д33Т11.2.1.ҮД6. Сурагч үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи дарааллын дагуу эсгэж, оёж чаддаг болно.	Д33Т11.2.1.ҮД6.Ш3. Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулах замаар хэрэглээг тодорхойлдог.
		Д33Т11.2.1.ҮД6.Ш4. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи дарааллын дагуу эсгэдэг.
		Д33Т11.2.1.ҮД6.Ш5. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг загварын онцлогт нийцүүлэн эмждэг.
		Д33Т11.2.1.ҮД6.Ш6. Үндэсний загвартай орчин үеийн хувцсыг технологи үйл явц, дарааллын дагуу оёдог.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
Д33Т11.2.1.ҮД5.Ш1. Монгол дээлний суурь үлгэрийг загварчилгааны аргуудаар өөрчилж загварчилдаг.	Хувцасны загварын онцлогт тохирсон загварчилгааны аргыг сонгодог.	Монгол дээлийн бүрдэл хэсгийг (энгэр, зах, ханцуй, хормой) өөрчилж загварчилдаг.	Сонгосон загварын онцлогт нийцүүлэн монгол дээлийг өөрчилж загварчилдаг.	Сонгосон загварт нийцсэн шинэ үлгэрийг зохион бүтээдэг.
Д33Т11.2.1.ҮД5.Ш2. Мөртэй хувцасны суурь үлгэрийг үндэсний хэв маяг, хэлбэрт оруулан өөрчилж загварчилдаг.	Хувцасны загварын онцлогт тохирсон загварчилгааны аргыг сонгодог.	Мөртэй хувцасны бүрдэл хэсгүүдийг үндэсний хэв маяг, загварт оруулан өөрчилж загварчилдаг.	Сонгосон загварын онцлогт нийцүүлэн мөртэй хувцсыг үндэсний хэв маяг, загварт оруулан өөрчилж загварчилдаг.	Сонгосон загварт нийцсэн шинэ үлгэрийг зохион бүтээдэг.
Д33Т11.2.1.ҮД6.Ш3. Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулах замаар хэрэглээг тодорхойлдог.	Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулж, зураг, бүдүүвч ашиглан тайлбарладаг.	Байгалийн гаралтай ба хиймэл торгыг гадаад байдал, (гялалзалт, үрчийлт, бат бөх) шатах шинж чанараар (шатах байдал, үнэр, үнс) нь туршиж ялгадаг.	Байгалийн гаралтай ба хиймэл торгыг физик, хими, механик, технологийн шинж чанараар нь харьцуулах замаар хэрэглээг тодорхойлдог.	Үндэсний загвартай орчин үеийн хувцасны зориулалт, загварын онцлогт нийцүүлэн материалыг сонгодог.
